СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭРГЭШСЭН СУВИЛАГЧДЫН СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ

Л.Одгэрэл[1], З.Хишигсүрэн [2], Д.Солонго [3], Н.Сүмбэрзул[4], Fiona Nolan[5]

АШУҮИС, СС[1], АУС[2] , ESSEX Их Сургууль
odgerel.l@mnums.edu.mn

Түлхүүр үг:
Сэтгэцийн эрүүл мэнд, мэргэшил, сувилагч, сургалт, үнэлгээ.

Товч утга: Монгол улсад СЭМҮТ, АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулиуд Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн чиглэлээр төгсөлтийн дараах сургалтаар “Сэтгэцийн эрүүл мэндийн сувилагч”-ийг бэлтгэж байна[1]. Сувилагч бэлтгэдэг сургуулиудын сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй хичээлийн хөтөлбөрийн агуулга харилцан адилгүй, сургалтын орчин, сургалтын арга барил орчин үеийн хандлагын жишгээр боловсронгуй болж чадаагүй байна.[2] Хөдөө орон нутгийн сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчдын сувилахуйн сургалтын талаар үнэлгээг хийхэд судалгааны зорилго оршино. Бидний судалгаанд хөдөө орон нутгийн сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн 46 сувилагч мэргэжилтэн хамрагдсанаас 46 (100%) нь эмэгтэйчүүд байна. Хөдөө орон нутгаас СЭМҮТ-д ирж суралцсан мэргэшсэн сувилагчдад сургалтын орчин (31) 67.4% нь тохилог, боломжийн гэж үнэлсэн бол (13) 28.3 нь орчин дунд зэрэг байсан гэж үнэлсэн байна. Харин СЭМ-ийн сувилахуйн мэргэшсэн сургалтын онол, дадлагын хичээлийн уялдаа холбоо (14) 30% дунд зэрэг гэж үнэлсэн байна. Мэргэшүүлэх сувилахуйн сургалтын хөтөлбөрийн агуулга нь мэргэжлээрээ ажиллахад хангалттай мэдлэгийг олгож чаддаггүй, сургалтын явцад гардан үйлдэл хийх боломж багатай байгаагаас үзэхэд цаашид сургалт явуулдаг байгууллагууд сургалтын хөтөлбөрийн агуулгад анхаарч шинэчлэлт хийх хэрэгтэйг харуулж байна.

Үндэслэл: Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын судалгаагаар 2010 онд ихэнх улс орнуудад сувилагч нар эрүүл мэндийн анхан шатны болон төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээнд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хамгийн том мэргэжлийн баг байдаг. Гэсэн хэдий ч олон улс оронд сувилагчдын сэтгэцийн эрүүл мэндийн талаарх боловсрол хангалтгүй, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх үүрэг нь төдийлөн хөгжөөгүй гэж гадаадын зарим судлаачдын бүтээлд тэмдэглэсэн байна[3].

Сувилагч бэлтгэдэг сургуулиудийн сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй хичээлийн хөтөлбөрийн агуулга орчин үеийн хандлагын жишгээр боловсронгуй болж чадаагүй тул сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн сувилагчдаас сургалтын талаарх үнэлгээг авах зорилго нь энэхүү судалгааны үндэслэл болно.

Зорилго: Хөдөө орон нутгийн сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчдын сувилахуйн сургалтын талаар үнэлгээг хийхэд судалгааны зорилго оршино.

Зорилт:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн мэргэшүүлэх сургалтын орчинг үнэлэх
2. Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр сургалтын явцыг үнэлэх


Судалгааны арга аргачлал: Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчийн сургалтанд үнэлгээ хийхэд дескриптив судалгааны загвараар хийв. Судалгаанд хөдөө орон нутгийн 19 аймгийн сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн чиглэлээр мэргэшсэн 46 сувилагчийг хамруулан, 2020 оны 06-р сараас 2020 оны 9 дүгээр сарын хооронд хийв. Судалгааны зорилтын хүрээнд мэдээ, мэдээлэл цуглуулахдаа тоон судалгааны асуумжийн аргыг хэрэглэв. Судалгааны боловсруулалтыг SPSS-24 программ ашиглан хийв.

Үр дүн: Бидний судалгаанд хөдөө орон нутгийн сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн 46 сувилагч хамрагдсанаас 100% эмэгтэйчүүд, дундаж нас 39.15±9.60 байна. Судалгаанд оролцогсдын 15.2% нь 45 хоногийн курсээр, 43.5% нь 3 сараар, 41.3% нь 4 сараар тус тус суралцан мэргэшсэн байна.




Зураг 1. Сургалтын орчны үнэлгээ

Судалгаанд хамрагдагсдаас сургалтын орчин хэр зэрэг байгааг үнэлж үзэхэд: (31) 67.4% нь тохилог, (13) 28.3% нь дунд зэрэг, 4.3% нь хангалтгүй гэж үнэлсэн байна. Ном, сурах бичгийн хүрэлцээний байдлыг судлахад 50% нь хангалттай, 41.3% нь дунд зэрэг, 8.7% нь хангалтгүй гэж хариулжээ.



Зураг 2. СЭМ-ийн мэргэшсэн сувилагчийн онол, дадлагын хичээлийн уялдаа

СЭМ-ээр мэргэшсэн сувилагч нар сургалтын онол, дадлагын хичээл хоорондын уялдаа холбоог (29) 63% нь хангалттай, (14) 30% дунд зэрэг (3) 7% нь хангалтгүй гэж үнэлсэн байна. Тухайн үеийн хичээлийн агуулга одоогийн мэдлэгийн хэрэгцээг хэрхэн хангаж буйг үнэлэхэд 23.9% нь маш сайн, 54.3% нь сайн, 19.5% нь дунд зэрэг, 2.3% нь хангалтгүй гэж дүгнэжээ.



Зураг 3. СЭМ-ийн сургалтанд хичээл заадаг багшийн заах ур чадварыг үнэлсэн байдал

Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн сургалтанд хичээл заадаг багш нарын ур чадварыг үнэлэхэд эмч, сувилагч мэргэжлийн багш нар чадварлаг сайн гэж (24) 52.2% нь үнэлсэн ч эмч багш (14) 30.4% нь илүү чадварлаг гэжээ.

Хэлцэмж: ЭМЯ-аас 2011 онд Анагаахын чиглэлээр сургалт явуулдаг сургуулиудын “Сэтгэцийн эрүүл мэндийн хичээлийн төгсөлтийн өмнөх сургалтын хөтөлбөр, стандартын өнөөгийн байдал”-ыг судалсан судалгаанд нийт судалгаанд оролцогчдын 74% нь энхүү сургалтын ном сурах бичиг, гарын авлага хангалтгүй байдаг гэсэн судалгааны дүн бидний судалгаанд 41.3% нь дунд зэрэг, 8.7% нь хангалтгүй гэсэнтэй дүйцэж байна. Ickley M.T, Forbes M. нар судалгаандаа (2010) сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад сургалтын хөтөлбөрт агуулгын шинэчлэлт хийх хэрэгтэйг хөндсөн байна[4]. Бид судалгаандаа хичээлийн агуулга одоогийн мэдлэгийн хэрэгцээг хэрхэн хангаж буйг үнэлэхэд 19.5% нь дунд зэрэг, 2.3% нь хангалтгүй гэсэн нь манай орны мэргэшсэн сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчлэх хэрэгтэй байгаатай ойролцоо байна.

АНУ-ын сэтгэцийн эрүүл мэндийн сувилагчийн нийгэмлэгээс (2013) сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагч нарын дунд хийсэн судалгааны үр дүнд ажлын байрны болон суралцах орчинг бүрдүүлэх, мэргэшсэн сувилагчийг хөгжүүлэх шаардлагатай[5] гэж 58% нь хариулсан байна. Харин бидний судалгаанд сургалтын орчинг 28.3% нь дунд зэрэг, 4.3% нь хангалтгүй гэсэн нь цаашид сургалтын орчинг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Дүгнэлт:

1. Судалгаанд хамрагдагсдын 32.6% нь сургалтын орчинг дунд ба түүнээс доогуур үнэлсэн, ном, сурах бичгийн хүрэлцээг 41.3% нь дунд, 8.7% нь хангалтгүй гэсэн нь бидний анхаарлыг татаж байна.
2. СЭМ-ээр мэргэшсэн сувилагчийн сургалтын онол, дадлагын хичээл хоорондын уялдаа холбоо 37% нь хангалтгүй, хичээлийн агуулга 19.5% нь дунд зэрэг, 2.3% нь хангалтгүй байгаа нь цаашид хичээлийн агуулгад шинэчлэлт хийх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Ном зүй:

1. *АШУҮИС, МСА-ны тайлан. 2019.Х. 24.*
2. *ЭМЯ. “Сэтгэцийн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр дахь (2010-2019) хөтөлбөр дэх “Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж”-д хийсэн хөндлөнгийн үнэлгээний тайлан.*
3. *Jones, A. and Jones, M. (2005), Mental health nurse prescribing: issues for the UK. Journal of Psychiatric and Mental Health Nursing, 12: 527–535. Kevin Gourney (1996) Advances in Psychiatric Treatment, mental health nursing: issues and roles. vol.2, pp.*
4. *Hickley M.T, Forbes Talamanca IF.[Mental health in the hospital. Analysis of conditions of risk by department, age and gender, for the creation of best practices for the health of nurses]. 2015 Jan-Mar;37(1):46-55.*
5. *World Health Organization (1998). Neurological Disorders: Public Health Challenges. Switzerland: World Health Organization. pp. 204–207. ISBN 978-92-4-156336-9.*

ASSESSMENT ON SPECIALIZED NURSES' TRAINING OF THE MENTAL HEALTH IN URBAN AREAS

Odgerel. L[1], Khishigsuren. Z [2], Solongo.D [3]

School of Nursing, MNUMS[1], School of Medicine[2]
odgerel.l@mnums.edu.mn

Mental health nursing is only prepared by State mental health national center and MNUMS. Mental health nursing curricula of the different schools which prepare mental health nurses are varied as well as training environment and training methodologies are not met the modern standard yet. This study aimed to assess the specialized training for the mental health nurses in urban areas of Mongolia. Specialized mental health nurses of 46 from urban areas are involved in this study were 46 (100%) female. Specialized mental health nurses who studied at State Mental Health National center from urban areas assessed the training environment comfortable or acceptable was (31) 67.4% and medium was (13) 28.3%. And theory of the specialized training and correlation of the theoretical session and practice were assessed medium (14) 30%. Specialized training contents are not providing the enough knowledge for further professional practice and manual practicum of intervention is not enough during training shows that the training organizations need to innovate and improve the training contents.

Key words: mental health, nurse, training, assessment, specialization